



ГАРЧИГ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|--|------|
| 364. | Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай | 1405 |
|------|--|------|

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|-----------|------|
| 365. | Монгол Улсын Засгийн газрын зарим гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай | Дугаар 63 | 1406 |
|------|---|-----------|------|

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|------------|------|
| 366. | Хөдөө аж ахуйн давхар даатгалын хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай | Дугаар 280 | 1407 |
|------|--|------------|------|

- | | | | |
|------|--|------------|------|
| 367. | Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх төслийн нэгжийг байгуулах тухай | Дугаар 285 | 1407 |
|------|--|------------|------|

- | | | | |
|------|--|------------|------|
| 368. | Монгол Улсын 2014 оны төсвийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай | Дугаар 291 | 1408 |
|------|--|------------|------|

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 10 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2012 оны 08 дугаар сарын 16-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын “Гадаад харилцааны сайд” гэснийг “Гадаад харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагааны сайд” гэж, 8 дахь заалтын “Барилга, хот байгуулалтын сайд” гэснийг “Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд” гэж, 18 дахь заалтын “Эрчим хүчний сайд” гэснийг “Уул уурхай, эрчим хүчний сайд” гэж, 8 дахь заалтын дугаарыг “10” гэж, 9, 10 дахь заалтын дугаарыг “8, 9” гэж, 12 дахь заалтын дугаарыг “11” гэж, 14-16 дахь заалтын дугаарыг “13-15” гэж, 18 дахь заалтын дугаарыг “12” гэж, 19 дэх заалтын дугаарыг “16” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. 2012 оны 08 дугаар сарын 16-ны өдөр баталсан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 11, 13, 17 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



3 дугаар зүйл. Энэ хуулийг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 10 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

**Монгол Улсын Засгийн газрын зарим
гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39¹ дүгээр зүйлийн 39^{1.2} дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Доор дурдсан хүмүүсийг Засгийн газрын гишүүн, сайдын үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй:

1/Лувсанвандангийн Болдыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Гадаад харилцааны сайдын;

2/Чүлтэмийн Улааныг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Сангийн сайдын;

3/Цэвэлмаагийн Баярсайханыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Барилга, хот байгуулалтын сайдын;

4/Амаржаргалын Гансүхийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн сайдын;

5/Даваажавын Ганхуягийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Уул уурхайн сайдын;

6/Нямжавын Батбаярыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эдийн засгийн хөгжлийн сайдын;

7/Мишигийн Сономпилийг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Эрчим хүчний сайдын.

2. Энэ тогтоолыг 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

3.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 8 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 280

Улаанбаатар
хот

Хөдөө аж ахуйн давхар даатгалын хуулийн этгээдийг үүсгэн байгуулах тухай

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөө, аж ахуйн давхар даатгалын үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэг бүхий “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компанийг үүсгэн байгуулсугай.

2. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэгчээр Сангийн сайд Ч.Улааныг томилсугай.

3. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компанийг үүсгэн байгуулах зорилгоор Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд заасан хөрөнгийн эх үүсвэрийг зориулалтын дагуу “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хувьцаат компанийн дансанд шилжүүлэх, үлдэгдэл эх үүсвэрийг Монгол Улсын 2015, 2016 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах, цаашид хуулийн дагуу төсвөөс санхүүжүүлэхээр заасан хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 9 дүгээр
сарын 4-ний өдөр

Дугаар 285

Улаанбаатар
хот

Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх төслийн нэгжийг байгуулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх төслийн нэгжийг байгуулж, түүний үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Татварын ерөнхий газар (Т.Батмагнай)-т даалгасугай.

2. Нэмэгдсэн өртгийн албан татварын урамшууллын системийг хөгжүүлэх төслийн нэгжийн үйл ажиллагаанд нэн тэргүүнд шаардлагатай байгаа зардлыг Сангийн сайдын 2014 оны төсвийн багцаас гаргах, бусад



зардлыг 2015 оны төсөвт суулгаж санхүүжүүлэхийг Сангийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 9 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 291

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2014 оны төсвийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 12.1.17, 34.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сангийн сайд Ч.Улаанд даалгасугай:

1.1. Улсын төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан мөнгөн хөрөнгийн зохицуулалтын хүрээнд санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийг бууруулан зохицуулж байх.

1.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг банкны урьдчилгаа төлбөрийн баталгаагаар олгохыг зогсоох;

2. Улсын нэгдсэн төсвийн хэрэгжилтийг хангах зорилгоор төсвийн бүх шатны эрх захирагч нарт даалгасугай:

2.1. Төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан олгосон санхүүжилтийн хүрээнд үйл ажиллагаагаа оновчтой зохион байгуулж, төсвийн сахилга хариуцлагыг өндөржүүлж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

2.2. Улс, орон нутгийн төсвийн урсгал болон хөрөнгийн зардлаар 9 дүгээр сарын 19-нөөс хойш хийгдсэн худалдан авахаар төлөвлөсөн бараа, ажил, үйлчилгээний тендер зарлах, дүгнэх, гэрээ байгуулах ажлын санхүүжилтийг энэ оны төсвөөс санхүүжүүлэхгүй байх, ирэх оны төсвийн төсөлд тусган хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж ажиллах.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

САНГИЙН САЙД

Ч.УЛААН

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 0.25

Индекс: 14003